

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН
БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2018.07.27

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 70 хуулийн 392 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 78 хуулийн 197 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 26 хууль буюу 33.3 хувь, 105 хэсэг, заалт буюу 26.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 56 /давхардсан тоогоор/ хуулийн 287 хэсэг, заалт буюу 73.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 14 хуулийн 18 хэсэг, заалтыг хяналтаас хассан тухай мэдээг ирүүлж, өмнөх онуудад хяналтаас хасагдсан 49 хуулийн 74 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны жилийн эцсийн байдлаар хяналтанд авсан	70	392
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	78	197
-	Хяналтанд байгаа	26	105
-	Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хассан	49	74

- 2017 оны хагас жилээр хяналтаас хасагдсан 14 18

3	Засгийн газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	56	287
---	---	----	-----

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 26 хуулийн 105 хэсэг, заалтаас 13 хуулийн 23 хэсэг, заалт буюу 21.9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 хуулийн 11 хэсэг, заалт буюу 10.5 хувь нь хэрэгжих шатанд, 23 хуулийн 58 хэсэг, заалт буюу 55.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 12 хэсэг, заалт буюу 11.4 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 16 хуулийн 91 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар 10 хуулийн 24 заалт буюу 26.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 3 хуулийн 4 заалт буюу 16.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 5 хуулийн 5 заалт буюу 20.8 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 7 хуулийн 9 заалт буюу 37.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 заалт буюу 4.2 хувь нь хэрэгжээгүй, 2 хуудийн 5 заалт буюу 20.8 хувь нь үнэлэх боломжгүй байна.

Хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Хууль /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	16	91	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	10	24	26.4
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	3	4	16.6
- Хэрэгжих шатанд	5	5	20.8
- Хэрэгжилт хангалтгүй	7	9	37.6
- Хэрэгжээгүй	1	1	4.2
- Үнэлэх боломжгүй	2	5	20.8

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн сангийн хяналтанд байгаа дараах 9 хуулийн 67 зүйл, хэсэг, заалт буюу 73.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

1. Жолоочийн даатгалын тухай /2011.10.06/ хуулийн 11.2, 15.5, 17.4, 19.8, 20.6, 21.3, 25.3, 26.2, 26.4 дэх заалт;
2. Инновацийн тухай /2012.05.22/ хуулийн 17.1.12 дах заалт;
3. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай /2015.06.26/ хуулийн 8.1.7 дах заалт;

4. Үйлдвэрлэлийг дэмжих тухай /2015.07.09/ хуулийн 6.1.1 дэх заалт;
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай /2015.11.26/ хуулийн 7.5, 7.6, 9.3, 10.2 дах заалт;
6. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга 2017.02.10/ хуулийн 5.2, 23.1.4, 23.1.7, 25.4, 29.4 дэх заалт;
7. Авто замын тухай /Шинэчилсэн найруулга 2017.05.11/ хуулийн 6.3, 8.2, 8.6, 9.1.1, 9.1.3, 9.1.4, 9.1.5, 9.1.7, 9.1.8, 10.1.2, 10.1.3, 10.1.6, 10.1.7, 19.3, 21.2, 22.8, 24.7, 26.2, 27.4, 28.3, 30.1, 30.2, 31.2, 33.2 дах заалт;
8. Үндэсний төлбөрийн системийн тухай /2017.05.31/ хуулийн 9.3, 12.3, 13.1, 18.5, 27.3, 33.1, 33.2, 34.1 дэх заалт;
9. Усан замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга 2017.05.25/ хуулийн 5.1.1, 5.1.3, 5.1.4, 5.1.5, 6.1.4, 6.1.5, 6.1.7, 6.1.8, 6.1.9, 6.1.12, 6.1.13, 10.1, 11.2, 16.3 дах заалт зэрэг болно.

Мөн дараах 5 хуулийн 5 хэсэг, заалтын хувьд өмнөх онуудад ирүүлсэн хэрэгжилтийн мэдээтэй харьцуулахад 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт, үр дүн буурч ирсэн байна. Тухайлбал,

1. Зээлийн батлан даалтын сангийн тухай /2012.02.10/ хуулийн 11.2 дах заалт;
2. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай /2015.06.26/ хуулийн 7.1.4 дах заалт;
3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай /2015.11.26/ хуулийн 13.2 дах заалт;
4. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2015.06.19/ хуулийн 5.3.5 дах заалт;
5. Барилгын тухай /шинэчилсэн найруулга 2016.02.05/ хуулийн 14.9 дэх заалт зэрэг болно.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1.Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 171 заалтыг хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 45 тогтоолын 106 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 20 тогтоолын 48 заалт буюу 28.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 57 /давхардсан тоогоор/ тогтоолын 123 заалт буюу 72.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 17 тогтоолын 27 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 31 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 20 тогтоолын 48 заалтаас 11 тогтоолын 18 заалт буюу 37.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10 тогтоолын 22 заалт буюу 45.8 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 4.3 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

3.2.Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт Улсын Их Хурлын 20 тогтоолын 51 заалтыг Мэдээлэл,

хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний Улсын Их Хурлын 5 тогтоолын 10 заалт буюу 19.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 15 тогтоолын 41 заалт буюу 80.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл, 2 тогтоолын 2 заалт буюу 20.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 тогтоолын 5 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 10.0 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 20.0 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

УИХ-ын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	20	51	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	5	10	19.6
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	2	2	20.0
- <i>Хэрэгжих шатанд</i>	3	5	50.0
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	1	10.0
- <i>Хэрэгжээгүй</i>	-	-	-
- <i>Үнэлэх боломжгүй</i>	2	2	20.0

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн сангийн хяналтанд байгаа дараах 16 тогтоолын 41 заалт буюу 80.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

1. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай /2012.01.05 №01/ тогтоолын 1.1, 1.2, 1.3 дах заалт;
2. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай /2012.10.25 №52/ тогтоолын 1.1, 2.1, 3.1 дэх заалт;
3. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2013.01.10 №06/ тогтоолын 1.2, 1.3 дах заалт;
4. Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай /2014.06.05 №41/ тогтоолын 1.1 дэх заалт;
5. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2014.11.13 №69/ тогтоолын 2.1, 2.2, 2.5, 3.1, 3.2, 5.1 дэх заалт;
6. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2015.11.13 №93/ тогтоолын 3.1, 3.3, 3.4 дэх заалт;
7. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай /2015.11.26 №104/ тогтоолын 2.1 дэх заалт;

8. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай /2016.02.05 №19/ тогтоолын 2.1, 2.2 дах заалт;
9. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /2016.09.09 №45/ тогтоолын 2.1, 2.2 дах заалт;
10. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай /2016.11.24 №70/ тогтоолын 2.1, 3.1 дэх заалт;
11. Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.12.28 №81/ тогтоолын 1.1, 1.2, 2.1, 2.2 дах заалт;
12. Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2017.02.10 №23/ тогтоолын 2.1, 3.1, 4.1 дэх заалт;
13. Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай /2017.05.31 №38/ тогтоолын 2.1 дэх заалт;
14. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай /2017.05.31 №42/ тогтоолын 2.1, 3.1 дэх заалт;
15. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2017.11.16 №70/ тогтоолын 1.1, 2.1, 3.1, 4.1 дэх заалт;
16. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай /2017.12.21 №87/ тогтоолын 1.1, 2.1 дэх заалт;

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 100 тогтоолын 544 заалтыг хяналтанд авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 46 тогтоолын 186 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлсэнээс, хяналтанд байгаа 36 тогтоолын 124 заалт буюу 22.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 81 /давхардсан тоогоор/ тогтоолын 420 заалт буюу 77.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 36 тогтоолын 124 заалтаас 18 тогтоолын 41 заалт буюу 33 хувь нь бүрэн хэрэгжсэн, 21 тогтоолын 53 заалт буюу 42.7 хувь нь хэрэгжих шатанд, 14 тогтоолын 23 заалт буюу 18.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.8 хувь нь хэрэгжээгүй, 5 тогтоолын 6 заалт буюу 5 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Мөн онуудад хяналтаас хасагдсан 13 тогтоолын 29 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 33 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Эдийн засгийн байнгын хорооны нийт 15 тогтоолын 95 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 2 тогтоолын 4 заалт буюу 4.3 хувийн хэрэгжилтийн мэдээг

ирүүлж, 13 тогтоолын 91 заалт буюу 95.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн тогтоолыг авч үзвэл, 1 тогтоолын 1 заалт буюу 25.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 1 заалт буюу 25.0 хувь нь хэрэгжих шатанд, 2 тогтоолын 2 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжилт хангалтгүй мэдээ ирүүлсэн байна.

	ЭЗБХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	15	95	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	2	4	4.3
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	1	1	25.0
- Хэрэгжих шатанд	1	1	25.0
- Хэрэгжилт хангалтгүй	2	2	50.0
- Хэрэгжээгүй	-	-	-
- Үнэлэх боломжгүй	-	-	-
Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	13	91	95.7

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа дараах Эдийн засгийн байнгын хорооны 13 тогтоолын 91 заалтын буюу 95.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байгаа нь Байнгын хорооноос гарсан тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэхээр байна. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2009.01.12 №17/ тогтоолын 1.1, 1.4 дэх заалт;
2. Хилийн хяналтын байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай /2009.10.21 №13/45/12/ тогтоолын 1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.10/ дах заалт;
3. Монгол Улсын өмнөд бүсийн ашигт малтмалын томоохон орд газруудад шаардагдах дэд бүтцийн хөгжлийн стратегийг тодорхойлох тухай /2009.11.03 №44/ тогтоолын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.6, 2.7 дах заалт;
4. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2010.06.08 №16/ тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7 дах заалт;
5. Авто зам, гүүрийн барилга угсралтын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай /2011.11.23 №23/ тогтоолын 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7 дах заалт;
6. Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай /2012.02.08 №10/ тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3 дах заалт;
7. Чиглэл өгөх тухай /2014.05.14 №07/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.8/, 2 дах заалт;
8. Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар /2015.04.08 №10/ тогтоолын 1.1/, 1.2/ дах заалт;
9. Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай /2015.04.17 №12/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 2.1/, 2.2/, 3 дах заалт;
10. Үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх талаар авах арга хэмжээний тухай /2015.04.17 №13 тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/ дах заалт;

11. Чиглэл өгөх тухай /2016.11.29 №07/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 2 дах заалт;
12. Чиглэл өгөх тухай /2017.06.07 №15/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.8/, 2 дах заалт;
13. Чиглэл өгөх тухай /2017.06.07 №16/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 2.1/, 2.2/, 2.3/, 2.4/, 2.5/, 2.6/, 3 дах заалт зэрэг болно.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 3 хуулийн 4 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 1 тогтоолын 1 заалт, Эдийн засгийн байнгын хорооны 1 тогтоолын 1 заалтыг хяналтаас хасах саналыг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, хяналтанд байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн ирүүлээгүй байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтыг дахин ирүүлэх, мэдээллийн санг шинэчлэхгүй байх, өмнө ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь хэмжээг бууруулан дахин ирүүлэх, шинээр хяналтанд авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй байх зэрэг дутагдалтай байна.

4/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хагас жил тутам ирүүлэхдээ хугацааны хувьд удаашралтай, 3-4 сарын дараа ирүүлж байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлэхэд хэрэгжилтийн мэдээний ач холбогдолыг бууруулах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай 2015.06.26	8.1.6 Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журмыг батлах;	"Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам"-ын төслийг боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 84 дүгээр тушаалаар батлан, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг улсын нэгдсэн бүртгэлийн 3644 тоотод бүртгүүлэн мөрдөж байна.
2	Эрчим хүч хэмнэлтийн тухай 2015.11.26	5.1.2 Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлах;	Хөтөлбөрийг боловсруулах хүрээнд АХБ-ны техникийн туслалцаагаар ОУ-ын эрчим хүчний хэмнэлтийн хүрээлэн "Монгол улсын эрчим хүчний үр ашгийн боломжийг үнэлэх нь" судалгааны ажлыг хийж дууссан. Судалгааны ажлын хэлэлцүүлгийг 2017 оны эхний хагас жилд зохион байгуулсан. Энэ баримт бичгийг үндэслэн "Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж урьдчилсан болон удаа дараагийн хэлэлцүүлгийг хийсэн. 2017 оны сүүлийн хагас жилд хөтөлбөрийн төслийг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээд, Засгийн газрын 2017.09.20-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор батлуулсан.
3	Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ 2016.02.05	21.2. Энэ хуулийн 21.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан ангилалын дагуу тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, бүртгэх журмыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Тус журам нь Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-тай ижил агуулгатай тул Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ын өдрийн 203 дугаар тушаалаар батлагдсан журамтай адилтган ойлгож болно. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлээд байна.

		<p>24.6. Барилгын үнэ бүрдлийн дүрэм, төсөв зохиох аргачлалыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/-ийг 1 дүгээр хавсралтаар, “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12/-ийг 2 дугаар хавсралтаар, “Барилга, сантехникийн ажлын төсвийн суурь нормын нэмэлт №4”/БНБД 81-02-12/-ийг 3 дугаар хавсралтаар, “Барилга, сантехникийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг нормын нэмэлт №1” /БНБД 83-29-12/-ийг 4 дүгээр хавсралтаар тус тус батлагдан мөрдөгдөж байна. Мөн сайдын 2017 оны 114 тоот тушаалаар “Барилга байгууламжийн үнийн индекс тооцох дүрэм” /БД 81-105-17/-ийг баталсан болно. Дүрмийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2012 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 3338 дугаарт бүртгүүлсэн.</p>
<p>Нийт 3 хуулийн 4 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	“Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2015.01.23 №11	2.2.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил хязгаарыг нарийвчлан тогтоож, ордыг иж бүрнээр ашиглах бодлого баримталж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/08 тоот тушаалаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд Эрдэнэтийн овооны зэс, Гацууртын алтны үндсэн ордын талбайн хил заагийг урьдчилан тогтоож газар дээр нь очиж ажилласан. Засгийн газрын 2017 оны 109 дүгээр тогтоолоор Гацууртын алтны үндсэн орд, Засгийн газрын 2017 оны 255 дугаар тогтоолоор Эрдэнэтийн овооны зэс, молибдений ордын талбайн хил заагийг тус тус тогтоосон.
Нийт 1 тогтоолын 1 заалтыг хяналтаас хасах саналтай байна.			

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	Чиглэл өгөх тухай 2015.07.07 №21	1.4/ Иргэний нисэхийн салбарын өнгөрсөн хугацааны болон өнөөгийн нөхцөл байдалд хяналт шалгалт, дүн шинжилгээ хийх замаар бодитой дүгнэлт өгч, цаашид катеринг, газрын үйлчилгээ, зорчигч бүртгэл, агаарын хөлгийн шатахуун хангалтын үйлчилгээг нэг компанийн монополь байдлаас гаргах, олон улсын стандарт, аюулгүй ажиллагааны түвшинд хүргэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	"Зам, тээврийн Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2016 оны 09 дүгээр сарын 21-ээс эхлэн 10 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн. Мөн Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг МИАТ ХК-д үйл ажиллагааны шалгалт хийсэн. Эдгээр хяналт шалгалтын үр дүнд үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 70 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан бүтцээр салбарын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг Дэд даргад хариуцуулж, нисэхийн үйлдвэрлэлийн асуудлыг Тэргүүн дэд даргад хариуцуулах замаар үйлдвэрлэл, түүний хяналтын чиг үүргийг тусгаарласан өөрчлөлтийг хэрэгжүүлсэн. Орон нутгийн агаарын тээврийг сэргээн тогтворжуулах, агаарын тээврийн үнэ тарифыг бууруулах талаар судалгаа хийж, санал боловсруулсан. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын катерингийн барилгыг Зураг төсөл боловсруулах-Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээгээр гүйцэтгүүлэх саналыг 2017.02.17-ны 03/722 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлээд байна."
Нийт 1 тогтоолын 1 заалтыг хяналтаас хасах саналтай байна.			